

Түмэн шөнө гэрэлтсэн цонх

Халимаггүй бөндийсөн буурал толгойтой өвгөн дарааллийн өмнүүр орох гэсэн чинь зарим нэг залуус уур нь бадарч:

Хөөе хөөе хөгшин талхи минь чи болиоч! Оочрын сүүлд оч энээ тэрээ болоход намхан бор өвгөн маань өврөөсөө жижигхэн үнэмлэх гаргалаа.

Цадиггүй залуус элдэв муу үгээр хашгичих дундуур үнэмлэхийг нүдний булангаар гүйлгэн уншвал Төв аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ахмад ажилтан гэсэн үгс дурайж байлаа.

Залуус түүнийг хайхрах янз алга. Гэтэл худалдагчийн зэвүү хүрч:

Та нар тэгэх бологүй шүү. Зовлон жаргал үзсэн хөөрхий амьтныг гомдоовол гээд авах гэснийг нь өгөөд явууллаа. Ай хөөрхий ямархан хүнээ өнөөгийнхөн ингэж хатуу, зөөлөн харцаар нэг агшинд аждаг юм болдоо.

1946 он

Өлзий хүүхний хүү сайхан залуу болоод иржээ. Дотоод яамны тусгай хороонд маршал Чойбалсангийн гэрийн харуул, бас тэр харуул сумангийнхаа дарга байсан юм байхаа!

1945 онд Жехеруу маршалын хамгаалалтад явсан гэнэ шүү. Эрдэм ном ч гэж мундаг болж. Ер нь толгойтой хүүхэд дээ. Тавтайдаа хойд сүмийн хуралд түвд ном үзээд уншлага төгсүүт Гандантэгчинлэнд арвантав хүртлээ суусан юм байхгүй юу гэсэн яриа Бадын голын айлуудаар найрын зар мэт тарж байлаа. Нээрээ ч тэр цэрэгт мордохоосоо өмнө нутгийнхаа эрдэмт эр Баярмагнай даргад шавь орж монгол үсэг бичигт сураад цэргийн 5 жилд шинэ үсэгт тайлдагдсан аж.

Хэдхэн хоногийн дараа Бадын голд Өнөө Өлзийн хүү Хаянхярвааг Эрдэнэсант сумын нарийн бичгийн дарга болгосон байлаа. Өлзий гуай баярлаж байна гэж жигтэйхэн гэсэн бас нэг шинэ мэдээ түгсэн юм.

Цэргийн даргийн зузаан хүрэн ширэн цүнхэнд албан хэргээ багтаасан залуу дарга Хаянхярваа төр засгийн алба анхдугаар 5 жилийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэх гэж морин дэл дээгүүр айлаас айлд ажлаа явуулж 6 жилийн нүүр үзтэл 1952 онд Эрдэнэсант сумын Хөдөлмөрчдийн Д ХГЗ-ын дарга болгож тэн ачааг нь чамбайруулаад авав.

Хэдийгээр албан боловсрол багатай ч хар ухаан цар, ард олны мэргэн зөвөлгөө өөрийн чармайлтаар сумын даргын албыг товхийтэл амжуулж явлаа. Дээд газрын тогтоол шийдвэр хэрэгжүүлж , жин хөдөлгөх, албан журам гүйцээх, хүүхэд сургуульд хөөх.... Сумын даргын ажил ер нь гүйцэгдэхгүй . Харин нэг сайхан тал нь ард түмэн их дуулгавартай учир хичнээн бэрх ажил алба боловч санаснаар хэрэгжинэ.

1956 оны 6 сар. Жаргах наран доогуур боронзон тоос манаруулсаар өртөөний машин сумын төв дундуур давхин шууд Хаянхярваагийн гадаа ирж тооромсоглов.

Мэнд ус, цай цүй болсны дараа жолооч:

Аймгийн дарга Бадамжав гуай танайхыг нүүлгээд ир гэж явууллаа гэв.
Хаянхярваа гуай халимаггүй толгойгоо илбэж надруу ажигласнаа:

Гайхах юмгүй дээ. Тэр цагт дарга нарын үг чинь зарлиг байхгүй юу. Шөнө нэг том хашаанд машин зогсоож манайхыг буулгалаа.

Хүүхдүүд бага, талийгаач маань залуухан, гэр орны ажилд түүртэхгүй. Ингээд аймгийн захиргааны ажилчдын байранд гэрээ барьчихаад аймгийн дарга Бадамжавын өрөөнд орлоо.

Ямар гээч ажил өгдөг юм бол, чаддаг болов уу гэж сэтгэл дэнсэлж байлаа.

Ингэж Төв аймгийн Хөдөлмөрчдийн депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний комиссын орлогч дарга болов оо гэв.

Тэр цагийн улс төрийн бодлогод төлөвлөлтийн үүрэг ач холбогдол их болоход аймгууд тоо бодлого тооцоонд чармахийсэн боловсон хүчнүүдээ татаж ажиллуулсны нэг нь Өлзийн Хаянхярваа гуай юм. Тоонд толгой өвдөхгүй явсан юм гэж үеийнхэн нь түүний чадварыг үнэлдэг. Ажлын газрынхаа бүтэц бүрэлдэхүүний тухай тэр дурсахдаа:

- Тэгэхэд Х.Шаравдорж аймгийн АДХ-ын нүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч бөгөөд төлөвлөгөөний комиссын дарга, төлөвлөгөөний комисс маань нэг орлогч, 3 байцаагчтай. Тоогоо сампиндана даа.

Хожуу гараар эргүүлдэг машинтай болсон юм.

Сургууль төгссөн боловсон хүчингүй болохлоор дарга маань бидэнд хичээл заана.

Багшлаад л, ажлаа хийгээд бид ч толгой өөд татах завгүй сууна даа....

Гүйдэг нэг, суудаг тавын гүехэн дульхан ажил гэж Тоншуул сэтгүүлд манаргаж явлаа.

Гүйдэг нэг нь би шүү дээ. Аймгийн гүйцэтгэх захиргааны статистикийн товчоо 1960 онд байгуулагдаад анхны даргаар нь намайг ажиллуулсан юм. Манай хэлтэс таван ажилтантай. Улс ардын аж ахуйн, соёлын төлөвлөлөөг жил, таван жилээр хийж улирлаар хувааж өгнө. Биелэлтийг тооцож гаргана. Улирал жилийн мэдээ бүртгэл үйлдэнэ. Аль ч даргад төл, мал, сүү, тос, хадлан тариалан, сургууль, соёлын болоод хүнсний комбинат Хоршоодын холбооны шаардсан үзүүлэлтийн биелэлтийн биелэлт ямар явааг хэзээд үнэн, бэлэн хэлэх үүрэгтэй. Боловсон хүчин, харилцаа холбооны чадал муухан болохоор мэдээлэл цуглуулах бэрхтэй.

Үүргээ биелүүлэхийн тулд бидний хэн маань ч шөнө дундаас өмнө ажлаас харьж явсангүй. Хагас бүтэн сайн өдөр гэж мэдэхгүй. Ээлжийн амралт авах хууль эрх нь бий ч тэгэж амарч ямбалж явсангүй.

Аймгийн намын хорооны дарга Рагчаатай төлөвлөлтөөр санал зөрснөөс Тоншуулд тоосоо өргүүлж явсан юм даа гэж Хаянхярваа гуай хөгжилтэй инээгээд:

-манай статистикийн хэлтэс чинь улсад уралдаанд дээгүүр байр эзэлдэг, шагнал алддаггүй явсан юм байхгүй юу. Харин ч бид төлөвлөлт тооцооны нарийн мэргэжил эзэмшээгүй ч социализм бол тооцоо, тоо бүртгэл гэсэн тэр л ажлынхаа ач холбогдол, шаардлагад чин үнэнч зүтгэж явсан улс гээд санаа алдлаа.

Ө.Хаянхярваа гуай тус аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд 31 жил ажилласны 3 жилд нь төлөвлөгөөний комиссын орлогч, 9 жилд статистикийн хэлтсийн даргаар ажилласан юм.: энэ он жилүүд буюу нэгэн түм илүү шөнө конторын нь цонх гэрэлтэй байсан юм шүү.

Хаянхярваа гуайн энгэрт хоёрын зэрэг алтан гадас одон хөдөлмөрийн хүндэт медаль ардын хувьсгалын ойн медалиуд, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан тэмдэг гялалзаж явна.

1945 оны чөлөөлөх дайнд оролцогч ахмад дайчин гээд ... энэ бүх шагнал, алдар цол түүний идэр залуу насаа хэний төлөө юунд үрснийг хэлүүлэлтгүй илтгэнэ.

Өчигдөргүй өнөөдөр гэж ирдэггүй, төлөвлөж товлодоггүй ажил үйлс гэж байдагүй болохоор хуучин төрд зүтгэсэн гээд ахмадуудад мартагнаж басамжлаж бас доромжлож болохгүй ээ!

(Ш.Цэрэндоогийн "Амьдрал шинжсэн тоочид" номоос)